

байна. Тэндээс Ванданьямын шарилыг хасаг тэргэнд ачиж хошууны бандид ламын сүмд авч ирэн хувьсгалт цэрэг, нутгийн олон түмний хамт гашуудан салах ёс гүйцэтгэжээ. Гашуудлын цуглаанд ДМАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчдээс /Сэрэндондов, Сайнбаяр зэрэг/ гадна Зөвлөлт болон БНМАУ-ын төлөөлөгчид оролцсон байна.⁷

Зүүлт тайлбар

1,2. Отгонбилэг, Улсын дотоодын нэг, хоёрдугаар хувьсгалт дайны үеийн Дотоод монголын ардын хувьсгалт нам, “Монголын түүхийн тухай өгүүллүүд”, Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо 1981 он, 327-р тал.

3. Удангүлэг, Монгол үндэстний орчин үеийн цуут хүмүүс, Өвөрмонголын Тунлян хот, 1990 он, 263-р тал.

4,5. Л.Жамсран, МАХН Өвөрмонголын ардын хувьсгалт нам үүсч бэхжихэд тусалсан нь “Дорно дахины асуудал” сэтгүүл, 1991 оны № 1, 13-р тал.

6. Отгонбилэг, Улсын дотоодын нэг, хоёр дугаар хувьсгалт дайны үеийн Дотоод монголын ардын хувьсгалт нам, “Монголын түүхийн тухай өгүүллүүд”, Өвөрмонголын ардын Хэвлэлийн хороо, 1981 он, 349-350-р тал.

7. С.Нарсан, Ордос ардын дугуйлангийн хөдөлгөөн” Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо, 1989 он, 299-р тал.

Сянганы үнэн түүх*

Д.Батхүү

Энд сүүлийн үед нилээдгүй анхаарал татаж байгаа Гонконгийг БНХАУ-д эргэн нэгдсэнтэй холбогдуулан тус арлын Англи-Хятадын түүхэнд хамаарах хэсгээс товч, мөн арлын нэрийн гарал үүслийн тухай, соёл боловсрол, ахуй амьдралын талаар цухас өгүүлэхийг зорив. Урд нь энэ талаар гарч байсан материалуудад үйл явдлын дарааллыг дурдсанаас бус, түүхэн учир шалтгааллыг хомс өгүүлсэн тул энэ тал дээр бас нилээдгүй анхаарахыг хичээлээ.

Сянган хэмээн нэрлэсний учир

БНХАУ-ын Гуандун мужтай Шэньчжэнь голоор хиллэсэн Синьцзе буюу Шинэ газар, өмнөд хятадын тэнгис дахь Цзюлуны хойг, Сянган арал орчмынхоо 235 жижиг арлын

хамт Их Британы эзэмшил дэх Гонконгийн нутаг дэвсгэрийг бүрдүүлж байжээ. Дэвсгэр нутаг нь хуурай газар болон далайд нийт 2905 км², хүн ам нь 6,21 сая (1995).

Сянган гэдэг нь тус арлын хятад нэр, “Үнэрт боомт” мөн “Үнэрт цутгалан” хэмээн монголчилж болох юм. Гонконг гэдгийн хувьд бол Хятадын дорнод эргийн хотуудыг европчууд өөрийн дуудлаганд тохируулан нэрлэж байсан бөгөөд (Аомэнийг Макао, Гуанчжоуг Кантон, Цзюлуныг Коулун г.м) энэ маягаар өгсөн нэр бололтой.

Сянган нь өнө эртний түүхтэй боловч, нэр нь нилээд хожуу үеийн судар бичгүүдэд тэмдэглэгдэн байдаг. Эдгээрээс хамгийн эртнийх нь Мин улсын үед хамаарах <<Юе да цзи>>(орчуулбал <<Гуандун аймгийн тэмдэглэл>>) хэмээх судар болно. Энэ номон дахь <<Гуандун аймгийн далайн эрэг дагуух нутгийн газрын зураг >>-т Сянган арал болон бусад газруудын нэрсийг тэмдэглэн үлдээжээ.

Харин Сянган хэмээн нэрлэсний тухайд хоёр янзын таамаг байдаг.

Үүнд: Үнэрт мод гарган худалдаалдаг боомт газар байсан учир түүгээрээ нэрлэгдсэн гэдэг. Энэ нь 1940 оны үест Юн Яны бичсэн <<Сянганы газар зүйн нэрийн судлал>> өгүүлээс эхтэй юм. Тэрээр “Сянган гэдэг нь далайн жижиг боомтын нэр бөгөөд үнэрт мод гарган худалдаалдаг байсан учир түүгээрээ нэршсэн юм” гээд мод зөөвөрлөдөг байсан замын маршрутыг зурж үлдээжээ.

Харин нөгөө нь арал дахь нэгэн булгийн нэрээр нэрлэгдсэн гэдэг яриа юм. Энэ тухай англи хэл дээр гардаг <<Чжунго цунбао>>(Хятадын цуврал сэтгүүл, сэтгүүлийн 1843 оны 8-р сарын дугаарын <<Сянганы газар зүйн товч танилцуулга>> өгүүлэлд гарчээ. Түүнд "Сянган-(Fragrant streams) гэдэг нь уг арлын өмнөд хэсэгт орших жижиг горхины нэр, гадаадынхан энэ нэрээр арлыг бүхэлд нь нэрлэсэн” хэмээн бичжээ.

Мөн Англи-Хятадын институтээс эрхлэн гаргадаг <<Ся'ер гуаньчжэнь>>(Хол ойрын сувдан хэлхээс) сэтгүүлийн 1853 оны 8-сарын 1-ний дугаарт хэвлэгдсэн <<Сянганы тухай товч тэмдэглэл>>өгүүлэлд "Уулнаа оргилон гарах булгийн ус нь амтлаг бөгөөд маш хүйтэн. Сянган нь үүгээр нэршсэнээс зайлахгүй” гэжээ. Үүнийг батлан тэр үед Сянганд амьдарч байсан нэрт эрдэмтэн Ван Тан И өөрийн эрхлэн гаргадаг <<Сюньхуань жибао>> (Ээлжит өдрийн сонин) сониныхоо

1874 оны 6-сарын 24-ний өдрийн дугаарт "Сянган нь булгийн нэрээр нэрлэгдсэн буй. Учир нь уулан дахь булгийн ус нь цэвэр тунгалагаас гадна үнэрлэж үзэхүл анхилуун үнэр үнэртэх мэт гэж бичиж байжээ.

Хоосон арал уу эсхүл...?

Гонконгийн хөгжлийн гайхамшгийг хэн хүнгүй шагшин магтаж, азийн "ууган" барын зиндаанд өргөмжилдөг. Гэхдээ нийгэм, эдийн засгийн ямар суурин дээрээс энэ хөгжлийн түүх эхэлсэн бэ гэдгийг төдийлөн сонирхдоггүй. Өнгөрсөн зууны 40-өөд оны үест Англичууд тус арлыг эзлэн авахад Сянган нь загасчдын жижиг тосгон, эсхүл бүр хоосон арал байсан гэлцдэг. Энэ нь бодит үнэнд нийцэх эсэхийг дараах баримтаас үзье.

Харин үсрэнгүй хөгжлийн түүх 1950-иад оноос эхэлсэн бөгөөд энд газар зүйн таатай байрлал, хятад хүний хөдөлмөрч чанар, үүн дээрээс англичуудаас олгосон улс төр, эдийн засгийн эрх чөлөө, 1970 оны сүүлчээс БНХАУ дорнод эргийн зарим районуудаа эдийн засгийн чөлөөт бүс болгон "нээлттэй хаалга"-ны бодлого хэрэгжүүлэх болсон зэрэг хэд хэдэн хүчин зүйл нөлөөлснийг дурдах хэрэгтэй.

1841 оны 5-р сарын 15-ны <<Сянганы сонин>>-д гарсан хүн амын тооллгын мэдээгээр тус арлын 1 хот, 15 тосгонд нийт 7450 хүн оршин сууж байжээ. Арлын төв нь Цзичжу хот, 2000 орчим хүнтэй байв. Энэ нь тус аралд английн цэрэг бууснаас хойш ердөө гурван сарын дараах баримт юм.

Сянган нь М.Э.Ө.III зууны сүүлээр Хятадын нутаг дэвсгэрт харъяалагдах болсон ч дөнгөж XI зууны үеэс эх газраас нүүдэллэн ирэгсэд газар тариалан эрхлэн арал дээр амьдрах болжээ.

XV-XVII зууны үед Хятадыг Энэтхэг, арабын орнуудтай холбосон худалдааны усан зам арлаар дайран өнгөрдөг байсан тул Сянган нь их зам тоссон далайн дээрэмчдийн орогнодог газар, дамжлага бааз болж байв. Мин улсаас Чин улсын эхэн үе хүртэл уг аралд далайн дээрэмчдийн "гүрэн" цэцэглэн мандаж

*Арлын нэрийн хувьд Хятадад харъяалагдаж байх үеийг Сянган, Их Британы эзэмшилд орж, нэгэнт олон улс, банк санхүүгийн харилцааны төв болсон байсан үеийг нь Гонконг хэмээн хэрэглэв.

байгаад XVII зууны сүүлчээр хоёр мужийн (Гуандун, Фуцзян) хамтарсан цэрэгт цохигдож сарнисан түүхтэй.

Чин улсын Төр гэрэлтийн тооллоос Энх амгалангийн тоолол хүртэл хөтөлж байсан <<Сянган зэрэг хязгаар нутгуудын му газарт оногдуулсан татварын байдал >> баримтаас үзэхэд газар тариалан өндөр хөгжсөн байсан бөгөөд хамгийн их эдлэн газартай Дэн овогтыг тэмдэглэн үлдээжээ.

1924 хэвлэгдсэн <<Чжунго тун шанту>> (Хятадын худалдааны бодлого) номонд 1838 онд Сянганд ирж байсан францын нэгэн зураачын тосгодын аж байдлыг зурж үлдээсэн зургууд оржээ. Зураач <<Сянганы тосгодын чөлөөнд>> гэдэг зурагтаа шахцалдсан олон сууц мухлагууд, үүгээр түүгээр хөлхөх амгалан тайван дүр төрхт хүмүүсийг дүрсэлсэн бол <<Сянганы усжуулах хоолой >> зурагт хулсан хоолой ашиглан талбайгаа усалдаг сонин аргыг үзүүлээд, "туйлын гайхамшигтай энэ хоолой нь хүмүүсийн сонирхлыг татаад зогсохгүй, нутгийн газар тариалангийн хөгжил харьцангуй өндөр шатанд байгааг гэрчилж байна" хэмээн бичжээ.

Мөн Цзюлуны хойг, Синьцзед газар тариалан, соёл боловсрол, худалдаа арилжаа тухайн үедээ өндөр түвшинд хүрсэн байв.

Сун улсын (960-1279) үед нэгэн ухаант түшмэл Дэн Фусе гэгч Гуандун аймгийн Янцюнь ордонд алба хашихаар явахдаа, далайн зам энэ нутгийн босгоор дайран өнгөрөх тул байглийн сайхныг ихэд таашаасан гэдэг. Тэрээр төрийн албыг залгуулж дуусаад нам тайван амьдралыг мөрөөдөн мөнөөх газраа ирж, газар шүтэж амьдрах болжээ.

Хожим Мин улсын үед Дэн овгийнхон 1000 му газартай үед дамжсан баячууд болцгоосон байсан гэдэг.

Мөн Хойд Сун улсын (960-1127) үед Хоу Улан гэгч нүүн ирж амьдрах болж, түүний хүү цайны газар нээн ажиллуулж, наймаа эрхлэн амьдарч байв.

Өмнөд Сун улсын(1127-1279) сүүлийн жилүүдэд эх газрын гүнээс Вэнь, Ляо, Пэн овогтнууд нүүдэллэн ирж, Дэн, Хоу овгийнхонтой нийлэн Синьцзегийн таван том овгийг үүсгэсэн түүхтэй.

Үүнээс гадна Сянганы оршин суугчид сувд шүүрдэх, далайн аялал зэргийг эрхэлж байсан баримт бий.

Мөн давс олзворлон хэрэглэдэг байсан бөгөөд одоогийн Цзюлун хот орчимд Сун улсын үеийн давсны томоохон орд газар байсныг 1955 онд илрүүлжээ. Давс олзворлолт нь зөвхөн

ахуйн хэрэглээний шинжтэй байсангүй, нэг хэсэг хүмүүсийн амьдрах арга хэрэгсэл бол байсан нь тус арал дээр 1197 онд гарсан давсчдын татварын дарамт эсэргүүцсэн бослого гэрчилнэ.

Тус хойгт худалдаа арилжаа хангалттай цэцэглэн хөгжиж байсны жишээ бол Төр гэрэлтийн 2-р онд(1822) бичигдсэн <<Сэргээн босгосон Хоу ван сүмийн чулуун бичээс>>-т уг сүмийг засварлахад мөнгө хандивлагсадын дотор 100 гаруй дэлгүүр, пүүсийн нэр байгаа явдал юм.

Цэюлуны иргэд газар тариалан, үйлдвэрлэл эрхлэхийн зэрэгцээ номын хүрээлэн, Хятадын эртний соёл түгээх газар, хичээлийн танхим зэргийг байгуулан өөрсдийн мэдлэг боловсролыг дээшлүүлдэг байжээ.

Эдгээрээс хамгийн эртнийх нь, Гуанчжоу зэрэг хотынхоос даруй 100 илүү жилийн түүхтэй, мөнөөхөн Дэн Фусегийн хурсан олонд ном хэлдэг байсан <<Ли ин>> хэмээх номын хүрээлэн юм.

Чин улсын үед өнөөгийн Сянганы нутагт дээрх газрууд нийт 499 байснаас үзэхэд нутгийн иргэд эртний соёлын өвтэй, боловсролтой хүмүүс байжээ.

Сянганыг булаан эзэлсэн нь

Их Британи дэлхийн колонилолын түүхэн дэхь хамгийн хүчирхэг гүрэн байсан агаад Ази, Африк, Америк, далайн орнуудад асар уудам газар нутаг эзэмшиж байсны нэг нь өгүүлэн буй Сянган юм.

Өнгөрсөн зууны 40-д онд Хятадын дорнод эрэгт ямар үйл явдал болсон хийгээд энэхүү арал бусдын эрхшээлд хэрхэн орсон тухай товч өгүүлье.

Өргөн уудам нутагт байгалийн баялаг нөөцтэй, хэрэглээний зах зээл өргөнтэй, эдийн засаг, улс төрийн тогтолцооны хувьд харьцангуй хоцрогдсон Хятад орон, колониудынхаа Хямд төсөр түүхий эд дээр суурилж байсан Английн капиталист үйлдвэрлэлийн хэрэгцээ, дэлхийн бүс нутгуудад өөрийн нөлөөг тогтоохоор улайрч байсан дипломат бодлого дахь Ази тивийн хамгийн чухал газар байв.

Гэвч Англичуудын Хятадад нэвтэрч холбоо тогтоох гэсэн удаа дараагийн оролдлого бүтэлгүй болсон нь Хятадыг гадаадынханд нээхэд зөвхөн дипломатын шахалт төдийгүй цэрэг зэвсгийн оролцоо зайлшгүй хэрэгтэй гэдгийг баталж өгчээ.

1813 онд Хятадад хар тамхины худалдааны онцгой эрхтэй байсан Отс-Энэтхэгийн компани өөрийн энэ эрхээсээ татгалзсан явдал Англи Энэтхэгийн хар худалдаачидад хууль бус наймааны үүд хаалгыг нээж өгчээ. Үүнд өмнөд Хятадын далайн боомт хот Гуанчжоу онцгой байр эзэлж байв. 1800 онд 4570 хайрцаг хар тамхи хууль бусаар орж ирж байсан бол 1838-1839 онд 40200 болтлоо өсч, хар тамхины наймаа, түүнийг хэрэглэх явдал жилээс жилд нэмэгдэн, Хятадаас цагаан мөнгө, торго цай зэрэг баялгийг сорон гаргах гол хэрэгсэл болж, улмаар Чин улсын эдийн засаг, нийгэмд ноцтой сөрөгөөр нөлөөлөхүйц хэмжээнд хүрчээ.

Энэ байдлаас улс орноо аврахын төлөө Манжийн төрд зүтгэж байсан Хятадын олон түшмэд тэмцэж байсны дотроос Хунань, Хугуан (одоогийн Хубэй мужийн амбан захирагч Линь Цзэсюй (1785-1850) товойн гарсан юм.

Мөн тэр үед хар тамхины худалдааг далдуур ивээн тэтгэж, ашгаас нь хувь хүртдэг Мучжана (1782-1856) зэрэг Чин улсын төрд нөлөөтэй манж нар эл наймааг дэмжиж байснаараа энэ тэмцлийг хагаралд хүргэж байв.

Манжийн эзэн хаан Минь Нинь(1782-1850.Оны цол нь Төр гэрэлт) энэ хууль бус наймааны улс төрийн агуулгыг ойлгож, түүнтэй тэмцэх албанд Линь Цзэсюйг тохоон, тэр үед энэхүү хууль бус наймааны хамгийн гол төв болох Гуандун мужид өөрийн бүрэн эрхт төлөөлөгчөөр томилжээ.

Тэрбээр 1839 оны эхээр Гуандунд ирж хар тамхины эсрэг хүчтэй тэмцэл эхлүүлэн английн худалдаачдаас 3 сая фунт стерлингийн үнэтэй 1402 кг тамхи хурааж, тэднийг дахин Хятадад худалдаа хийхгүй гэсэн амлалтад гарийн үсэг зурахыг шаарджээ. Ийнхүү Хятадуудын эх оронч тэмцэл өрнөж, английн компаниуд, худалдаачдын эрх ашиг ноцтой хөндөгдөж эхэлсэн нь Их Британы ГЯЯ-ны сайд Г.Пальмерстонд (1784 1865) өөрийн эрх ашгийг Чин улсад тулгаж, халдан түрэмгийлэх шалтаг болсон юм.

Тэр цэргийн ажиллагаа эхлүүлэх заавар өгч, 1840 онд английн цэргүүд Хятадын өмнөт эрэгт хүрснээр түүхэнд <<Хар тамхины>> гэж нэрлэгдэх болсон дайн эхэлсэн юм. Англичууд далайн зүгээс томоохон голуудаар эх газарт нэврэх замыг хааж, зарим районыг бүслэн цэргийн хүчээр давамгайлан сүрдүүлж <<Пальмерстоны нот>> гэгчийг Чин улсын засгийн газарт өгчээ.

Уг нотод зааснаар Хятад нь 1839 онд хураасаан хар тамхины үнийг буцааж төлөх, Сянган арлыг Их Британы мэдэлд өгөх зэрэг шаардлага тавьсан байна. Эдгээр асуудлаар Манжийн талаас эзэн хааны элч Ци Шань(1790-1856), Английн талаас Хятад дахь тус улсын худалдааны төлөөлөгч Ч.Эллиот(1801-1875) нар хэлэлцээ хийсэн боловч тохиролцоонд хүрсэнгүй, харин Гуандунд хэлэлцээрийг үргэлжлүүлэхээр болжээ.

Эхний хэлэлцээрийн үеэр Манжийн эзэн хаан нилээд хатуу байр суурьтай байсан боловч. Мучжанагийн бүлгийнхний нөлөө, англичуудын цэргийн сүрдүүлэгт автан хар тамхины талаар хэд хэдэн буулт хийсэн шийдвэр гаргасан нь нэг талаас шинээр хэлэлцээ эхлэхийн өмнө байдлыг зөөллөх, нөгөө талаас харийн түрэмгийлэгчдийн эсрэг хятадын ард түмний эсэргүүцэл өргөжин зохион байгуулалтанд орж, улмаар сулран ганхаж байгаа манжийн ноёрхлын эсрэг чиглэхээс эмээсэн хэрэг байв.

Мөн хоёр дахь хэлэлцээний өмнө Англичуудын түрэмгийлэл, хар тамхины эсрэг хамгийн шийдвэртэй тэмцэж байсан Линь Цзэсюйн албан тушаалыг эвдэж, оронд нь Ци Шанийг томилжээ.

Гуандуны хэлэлцээ 1840 оны 12-р сарын 4-нд эхэлж нийт зургаан долоо хоног үргэлжилсэн боловч мөн л тохиролцоонд хүрсэнгүй. Ци Шань <<Пальмерстны нот>>-ы бүх шаардлагыг зөвшөөрсөн боловч, гагцхүү Сянганыг өгөхөөс эрс татгалзжээ. Үүний хариуд Ч.Эллиот сүрдүүлгээ сэргээж, Гуандун муж дахь эргийн хоёр бэхлэлтийг эзлэн авч цаашид цэргийн ажиллагаа эхлүүлэхээр заналхийлжээ. Өөрийн захиргааны нутаг дэвсгэрт англичуудтай ноцтой сөргөлдөхөөс эмээсэн Ци Шань буулт хийж, Сянганыг Их Британы мэдэлд өгөхөөр 1841 оны 11 сарын 8-нд Эллиоттой нууцаар тохиролцжээ.

Гэвч энэ тохиролцоог Их Британы засгийн газар ч, Чин улсын эзэн хаан ч хүлээн зөвшөөрөөгүй юм. Учир нь Ци Шань тухайн үед оногдох хариуцлагаас айж энэ тухай эзэн хаанаас нуусан учир уг тохиролцоо хүчин төгөлдөр болж чадаагүй, английн тал ч тохиролцооны дүнд сэтгэл дундуур байсан зэргээс болжээ.

Гэсэн ч англичууд 1841 оны 1-р сарын 25-нд Сянганд цэрэг оруулж өөрийн захиргаанд орсныг зарлажээ.

Ийнхүү Сянган нь эрх тушаалтны амиа хичээсэн явуургүй бодлогын золиос болж харийн колони болсон юм.

Их Британы засгийн газар “албан үүргээ хангалтгүй биелүүлсэн” Эллиотыг чөлөөлж, оронд нь Генри Поттингерийг Хятадад томилжээ.

Поттингер уг арлыг цэргийн түрэмгийлэл, сүрдүүлэгт дулдуйдан 1842 оны 8-р сарын 29 (Төр гэрэлтийн 22-р оны 7-р сарын 24-нд байгуулсан <<Наньжины гэрээ-гээр өөрийн эзэмшилд өгөхийг Чин улсад тулган хүлээлгэж, өөрөө Сянганы анхны амбан захирагч болсон юм.

Мөн 1843 оны хоёр талын нэмэлт гэрээгээр Сянганд Их Британаас амбан захирагч томилох, Хятадаас Сянганд худалдаа хийх болон зорчин явах тухай зарчмын хувьд тохиролцжээ.

99 жилийн түрээс

Хар тамхины дайнаар(1840-1842) Сянган нь Хятад дахь английн цэрэг худалдааны бааз болон хувирсан төдийгүй цаашид колоничлолоо өргөжүүлэх түшиц газар болсон юм. Тэд Сянганы эсрэг талд орших Цзюлуны хойгийг эртнээс сонирхон, гагцхүү эзлэн авах аятай цагийг хүлээж байв.

Иймээс Чин улс тус хойг дахь Гуанфугийн харуулын Хэсгийг (Мин улсын үед, 1370 онд байгуулагдсан) Цзюлуны харуулын төв болгон өргөжүүлж, 1847 оноос Цзюлун хотыг барьж эхэлжээ.

1857 онд Сипайн бослого дарагдсаны дараа англичуудын Хятад дахь сонирхол улам идэвхижин.

Хятад дахь өөрийн төлөөний хүн Эльгинд английн эрх ашгийн төлөө улам шаргуу ажиллахыг шаардаж байв. Энэ сонирхол хар тамхины дайны(1856-1860) дараа илэрхий цэргийн ажиллагаанд шилжиж, мөн л цэрэг зэвсгийн давуу талаа ашиглан сүрдүүлэн шахамдуулах аргаа хэрэглэж байсан юм.

1860 оны зунаас Англи-Францын цэргийн Бээжин Тяньцины районд хийсэн интервенц Хятадын нийслэлд хүрч байдал ноцтой болмогц Чин улсын засгийн газар оросын элчээр зуучлуулан англичуудтай хэлэлцээ хийж эхэлжээ.

Францууд өмнөд Хятадад бэхжиж амжихаас өмнө Эльгин Цзюлуны хойгт Английн нөлөөг баттай тогтоохоор яаравчлан, хэлэлцээрт өөрийн давуу байр суурьтай байгааг ашиглан манж нарыг шахамдуулж эхэлжээ.

Ийнхүү англичууд эх газарт хийж байсан интервенцээ Хятадын нутаг дэвсгэрээс таслан авах зорилгодоо шахалт болгон ашиглаж 1860 оны 10-р сарын 24 байгуулсан <<Бээжингийн гэрээ>>-ний 6-р зүйлд заасны дагуу Цзюлуны хойгийн зарим хэсгийг Их Британид нэгтгэсэн юм.

Энэ үеэр хойгийг зөвхөн түрээслэх тухай яригдаж байсан боловч хэлэлцээрийн дараа аяндаа замхарчээ.

Хойгийн үлдсэн хэсгийг Синьцзегийн нутаг дэвсгэрийн хамт шинээр төрөн гарсан капиталист АНУ, Герман, Франц, Япон, европ, азид нөлөөгөө тэлж байсан Хаант Орос зэрэг гүрнүүд дэлхийг дахин хуваах тэмцэлд улайрч, Хятадад нөлөөгөө тогтоохоор Англитай илэрхий сөргөлдөж байсан XIX зууны сүүлчээр өөрийн эзэмшилд авсан юм.

Хятад-Японы дайны (1894) дараа их гүрнүүдийн оролцоо улам ширүүсч, Оросууд Манжуурт, Францууд Юньнань, Гуаньсид, Германууд Ханькоу, Тяньцзинд ноёрхох болж Английн байр суурийг улам ганхуулж эхэлсэнтэй уялдан тэд Хятад дахь нөлөөнийхөө хүрээг батжуулж эхэлжээ.

Энэ зорилгоор 1898 оны 6-р сарын 9-нд гарын үсэг зурсан <<Сянганы нутаг дэвсгэрийг өргөтгөх тухай гэрээ>> гээр Цзюлуны хойг, түүний орчмын арлуудыг Сянгантай нийлүүлэн 99 жилийн хугацаатай түрээслэн авчээ.

Зөвхөн Цзюлун хотод Чин улс хэлбэрийн төдий шүүн таслах эрхтэй үлдсэнээс бусад бүх нутаг болох Синьцзе, Цзюлуны хойг, Сянган, Ланьдао аралд Английн захиргаа тогтжээ. Гэрээнд Синьцзег Англичууд зөвхөн түрээслэн эзэмшиж, төлбөр төлөх асуудлыг хоёр тал тохиролцсон авч хэн нь ч энэ асуудлыг сөхөн тавьж байгаагүй юм.

“Хамтарсан тунхаг” ба “БНХАУ-ын Сянган”

Нэгэн зуун улиран өнгөрч хоёр орны хооронд дахин Гонконгийн асуудал босч ирэв. Гэвч энэ асуудлыг шинэ цаг үед, шинэ хандлагаар авч үзэх нь зайлшгүй болсон байлаа. 1949 онд коммунистууд засгийн эрхэнд гарч, Бээжин Гонконгийн колонийн статусыг үл зөвшөөрөн, түүнийг “булаагдсан нутаг дэвсгэр” хэмээн үзэж байлаа.

“Соёлын хувьсгал”, “Их үсрэлт” зэрэг дотоодын асуудал мундахгүй их байснаас БНХАУ Гонконгийн талаар удтал таг чиг байсан юм.

Гэсэн ч эл асуудлыг анхаарлынхаа гадна орхиогүй гэдгээ үе үе сануулж байв. 1963 оны 3-р сарын 8-ны <<Женьминь

жибао>> сонинд нийтлэгдсэн өгүүлэлд “Цаг нь болохоор асуудлыг хэлэлцээрийн замаар шийдвэрлэнэ, энэ болтол одоогийн байдлыг хэвээр хадгална” хэмээн ихэд битүү дурджээ. 1970-аад он болтол энэ баримтлалаас өөр тодорхой мэдэгдэл хийхгүй байв.

1972 оны 3-р сард БНХАУ НҮБ-д өөрийн зохих ёсны байр сууриа эзэлж, гадаад ертөнцөд удтал хаалттай байсан Хятадын үзэл суртлын хөшиг нээгдэж эхлэх үест Бээжингээс НҮБ-д суух төлөөлөгч Хуан Хуа колонийн асуудал эрхэлсэн байнгын хороонд илгээсэн мемарандумдаа “Сянган, Аомэнь нь БНХАУ-ын нутаг дэвсгэрийн салшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг болохыг мэдэгдээд “ямар нэгэн тусгаар гэсэн ойлголт байж таарахгүй агаад, тэднийг эргүүлэн нэгтгэх нь асуудлыг шийдвэрлэх цорын ганц зөв арга” болохыг хатуу анхааруулжээ.

Чухам үүний дараа л Гонконгийн талаар Англичууд нухацтай авч үзэн, түрээслэн эзэмших хугацааг цаашид сунгах, Синьцзег БНХАУ-д буцаан өгч бусад хэсэг дэхь Английн эзэмшлийг хэвээр байлгах зэрэг олон хувилбар дэвшүүлэн колонийн статусыг ямар нэгэн хэмжээнд хадгалахыг санал болгосон боловч олон улсын тавцанд нэгэнт гарч ирсэн, зохих хэмжээний нөлөөтэй болсон Хятад үүнийг эрс няцааж, Гонконг эх орондоо эргэн нэгдэх болно гэдгийг мэдэгджээ. Гагцхүү энэ өдрийн тов тодорхойгүй байлаа. Энэ хугацаа хэрхэн товлөгдсоноор БНХАУ Гонконгийн тэр үеийн статус Квог ямар хэмжээнд авч үзэж байгааг мэдэж болох байлаа.

Эдгээр алхамууд нь Гонконгийн асуудлаар хоёр тал зайлшгүй нэгдсэн байр сууртай болох шаардлагатай болсныг харуулж байлаа. 1982 онд Их Британы ерөнхий сайд М.Тетчерийн БНХАУ-д хийсэн айлчлалын үеэр энэ асуудлаар хоёр тал наацтай алхам хийж, хэлэлцээ эхлүүлсэн боловч санал зөрөлдөөний улмаас 2 жил гаруй сунжиран 1984 онд дөнгөж зохих үр дүнд хүрчээ.

Энэ хооронд БНХАУ-ын ерөнхий сайд Чжао Цзыян Японы сурвалжлагчдад өгсөн ярилцлагадаа БНХАУ Гонконгт өөрийн бүрэн эрхийг 1997 оны 7-р сарын 1-нд сэргээнэ гэж мэдэгджээ.

Бээжингийн байр суурь нэгэнт тодорхой болсон болохоор Их Британы засгийн газар асуудалд шуурхай хандаж ерөнхий сайд М.Тетчер Чжао Цзыянд илгээлт явуулж хэрэв БНХАУ Гонконгийн өнөөгийн тогтолцоог цаашид хэвээр

хадгалах баталгаа гаргасан нөхцөлд түүнийг эргүүлэн өгөхөд татгалзах шалтгаан байхгүйг мэдэгдсэн юм.

Үүнээс хойш БНХАУ-ын удирдагчид гадаадын сурвалжлагчидтай ярилцах далимдаа Гонконгийн капиталист тогтолцоог 50 жил хүртлэх хугацаанд өөрчлөхгүй, энэ нь 1984 онд Дэн Сяопины тодорхойлсон “нэг улс, хоёр систем”-ийн зарчимд суурилна гэдгийг дуртайяа мэдэгдэж байв.

Энэ үед төдийлөн үр дүнгүй явагдаж байсан хэлэлцээрүүд ч шуударч 1984 оны 12-р сарын 19-нд хоёр орны төрийн тэргүүн Чжао Цзыян Маргарет Тетчер нар “Хятад-Их Британы хамтарсан тунхаг”-т гарын үсэг зурснаар маргаантай асуудлуудад цэг тавьж, нэгдсэн байр сууринд хүрсэн юм.

Уг тунхаглалын дагуу Их Британи Гонконгийг “колонийн бие даасан байдал, капиталист тогтолцоог 50 жилд өөрчлөхгүй” гэсэн болзолтойгоор 1997 оны 7-р сарын 1 гэхэд хүлээлгэн өгөхөөр, БНХАУ үндсэн хуулийнхаа 31-р заалтын дагуу Гонконгийн одоогийн нутаг дэвсгэрт засаг захиргааны онцгой бүс байгуулахаар тогтжээ.

Мөн үүний хамт “БНХАУ-ын засгийн газраас Гонконгийн талаар баримтлах үндсэн бодлогын тайлбар”, “БНХАУ-Их Британы харилцааны хамтарсан хэсгийн тухай”, “Газрын түрээсийн тухай” зэрэг баримт бичгүүдийг гаргасан нь Гонконгийн нийгмийн тогтолцоо, бие даасан байдлыг хууль эрх зүйн үүднээс тодорхойлон баталгаажуулсан чухал ач холбогдолтой зүйл болсон юм.

Энэхүү үйл явдал нь БНХАУ-д Гонконгийг буцаан өгөхийг зөвшөөрсөн төдий бус, Хятад нэгэнт олон улсын хэмжээнд “нөлөөлж”, “өөрийгөө илэрхийлж” чадаж байгааг хүлээн зөвшөөрч, уг асуудлыг үндсэндээ Хятадад ашигтайгаар шийдвэрлэсэн нь БНХАУ-ын гадаад бодлого, дипломат харилцааны нэгэн том ялалт болсон юм.

Үлдсэн хугацаанд Хятадын тал Гонконгийг эргүүлэн авах бэлтгэлээ туйлын няхуур нямбай, гэхдээ хугацаа алдахааргүйгээр хийж эхэлжээ.

1990 оны 4-р сарын 4-нд Хятад, Гонконгийн хуульчдын 5 жилийн хөдөлмөрийн дүнд ирээдүйн Гонконгийн суурь болох хууль батлагдан гарсан юм.

Мөн 1996 оны 12-р сарын 11-нд Гонконгийн дөрвөн давхаргыг төлөөлсөн 400 хүнтэй сонгуулын хорооноос бизнесмен Тун Чихуаг тус бүсийн засаг захиргааны анхны тэргүүнээр сонгожээ.

Ийнхүү 1997оны 7-р сарын 1-ээс “Нэг улс, хоёр систем”, “Гонконг хүн Гонконгийг удирдана”, “Дээд хэмжээний өөртөө эрхт” гэсэн дотоод хүрээтэй, “БНХАУ-ын Гонконг”, “Батлан хамгаалах болон гадаад харилцаагаа хамаарахгүй байх гадаад хязгаартай бяцхан бүс нутаг оршин тогтнож эхэлсэн юм.

Ашигласан материал:

1. “Гуанмин жибао” сонины 1996 оны дугаарууд
2. Сладковский. М.И Китай и Англия. Москва. 1980.
3. “Бань юе тань” сэтгүүлийн 1993 оны 03.
4. Ипатова.А.С Патриотическое движение на юге Китая в 40-ые годы XIX в. Москва. 1976.

ӨМӨЗО-ны
50 жилийн ойд

Өвөр Монголын Өөртөө Засах
Орны Хөлөнбуйр аймаг.

Ч.Батцэцэг.

Хөлөнбуйр гэдэг нь Монгол улс, Өвөр Монголын нутаг дахь Хөлөн болон Буйр гэсэн хоёр том нуурын нийлсэн нэр юм. Өвөр Монголын Өөртөө Засах Орны /ӨМӨЗО/ зүүн хойд хэсэг, зүүн болоод зүүн хойд талаараа Хар мөрөн муж, урдуураа Хянган аймаг, хойд болон баруун хойгуураа Эргүнэ гол, Орос улстай, баруун болоод баруун урдуураа Монгол улстай тус тус хиллэдэг хилийн шугамын нийт урт 1700, 82 км, 250 мянган ам км талбайтай, 4 хот, 9 хошуу /түүний гурав нь өөртөө засах хоцуу/, засаг захиргааны төв нь Хайлар хот. Хайлар, Манжуур, Ягши, Залан зэрэг 4 хоттой. Нийт 255118 мянган хүн амтай, үүнээс монгол үндэстний хүн ам 18,54 мянга, ороочлон, солон, зүрчид, түнгүс гэх мэт бусад цөөнх үндэстний хүн ам 23,81 мянга байна.

Одоо Хөлөнбуйр аймгийн түүхийн хуудсыг сөхөж үзье. МЭӨ Ш зууны үед Байгал нуур орчмоос зүүн Монголын нутгаар нутаглаж байсан хори, түмэд, баргуд, буриад, ихрээд, түнгүс зэрэг ойн иргэд цөм Хүннүгийн нүүдэлчин аймгуудын холбоо болон гүрний захиргаанд багтаж байсан бөгөөд бүр эрт дээр үеэс монгол угсаатан Хөлөнбуйрын бүс нутагт аж төрж байсныг эртний Хятадын “Тан улсын судар”-т тодорхой өгүүлжээ. Үүнд: “Шивэй, хятан нар болон бусад.. нүүдэлчин